



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ. ХӨРС.
ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭЭЖ АВАХАД ТАВИГДАХ
ЕРӨНХИЙ ШААРДЛАГУУД**

MNS 3298 - 90

Албан хэвлэл

**БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны
Үндэсний стандартчиллын эрдэм шинжилгээний хүрээлэн
Улаанбаатар хот
1991 он**

1.БОЛОВСРУУЛСАН: Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл ахуй,
халдвар, нян судлалын улсын институт

ЗОХИОГЧИД: Ё.БАНЗАР (Секторын эрхлэгч, дэд эрдэмтэн)
С.ЧУЛУУНЦЭЦЭГ (Мэргэжилтэн)

БАТЛУУЛАХААР ОРУУЛСАН:

Эрүүл мэндийн яам
Г.ДАШЗЭВЭГ (Тэргүүн дэд сайд)

БАТЛАХАД БЭЛТГЭСЭН: БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны
Үндэсний стандартчиллын эрдэм
шинжилгээний хүрээлэн
Ц.ОТГОНБАЯР (ЭШДА)

2.СТАНДАРТЫН ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДЛАГЫН ТҮВШИН

Түвшинд хүрсэн буюу давсан бүлэг зүйлийн дугаар	Олон улсын буюу гадаад орны стандартын тэмдэглэгээ, бүлэг, зүйл
Стандарт бүхэлдээ	ГОСТ 17.4.3.01-83

3.СТАНДАРТАД ҮЗЛЭГ ХИЙХ ХУГАЦАА:

Анхны үзлэгийг 1995 онд, дараа нь таван жил тутамд

4.ИШ ТАТСАН СТАНДАРТ:

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

АБА

СТНА/0017

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ. ХӨРС. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. Охрана природы. Почва. Общие требования к отбору проб.	MNS 3298 - 90
Environmental protection. Soil. General requirements on the probe for analytical purposes.	

Улсын стандартчиллын шинжлэх ухаан техникийн Зөвлөлийн 1991 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолын дагуу 1991 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэнэ мөрдөнө.

Стандартыг зөрчвөл хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

1. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү стандарт нь БНМАУ-ын нэгдмэл сан хөмрөгт хамаарах бүх төрлийн хөрсний бохирдолт, ариун цэврийн байдлыг үнэлэх шинжилгээнд хөрсний дээж авахад тавих шаардлагыг тогтооно.

1.2. Энэ стандартыг хөрснөөс шинжилгээнд дээж авах, ажлыг гүйцэтгэж, зарим хөрсний шинжилгээ, зураг төсөл, эрдэм шинжилгээ, хяналтын бүх байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Энэ стандартаар физик, нян, вирус, шимэгч судлал, цацрагийн шинжилгээнд дараах шаардлага гарсан тохиолдолд хөрснөөс дээж авна.

Үүнд:

1/. Тодорхой нутаг дэвсгэрийн хөрсний тогтоц, бүтэц судлал, орд газрын эрэл хайгуул хийх;

2/. Хот суурин, барилга, инженерийн байгууламж, усан хангамжийн эх булгийг байгуулах, хүн амыг суурьшуулах талбайг сонгон авах;

3/. Хөрсний бохирдлын түвшин, өөрөө цэвэрших чадварыг тогтоох;

4/. Эрүүл ахуй, халдвар судлалын талаас хөрсний ариун цэврийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх.

2. Шинжилгээнд дээж авах цэг талбайг сонгох

2.1. Хөрснөөс шинжилгээнд дээж авах, тухай орон нутгийн цаг уур, газар зүйн нөхцөл, хөрсний хучилт, хотгор, гүдгэр, бохирдолтой байдал, бүтцээс хамааруулан хөрсний шаардлагатай бүх үе давхаргыг бүрэн төлөөлж чадахаар байгаа хэсэг газрыг сонгож авна.

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

MNS 3298 - 90

2.2. Их бага хэмжээгээр бохирдсон болон бохирдоогүй хэсэг үе давхаргын хөрснөөс авсан дээжүүдийн шинжилгээний үр дүнг харьцуулан дүгнэлт хийх боломжийг бүрдүүлэхээр сонгосон талбайгаас дээж авах цэг, дээжийн тоог тогтооно.

2.3. Шинжлэн судлах, хөрсний бохирдлын эх үүсвэрийг оролцуулан 25 м^3 талбай, түүнээс тодорхой зайд орших ашиглагдаагүй буюу цэвэр хэсэг мөн хэмжээний (25 м^2) жиших талбайг тус тус сонгон авна.

2.4. Хөрсний ердийн бохирдолтыг тодорхойлох дээж авахдаа тухайн талбайг хэсгүүдэд хувааж түүнийгээ дугаарлан, дугаар бүхий хэсэг бүрээс авна.

2.5. Адил хэмжээгээр нэлэнхүйдээ бохирдсон талбайн хэсэг бүрээс дээж авах талбай нь хэсэг бүрдээ ижилхэн хэмжээний зайд хуваагдсан байвал зохино.

2.6. Ижил биш хэмжээгээр бохирдсон хөрснөөс дээж авах талбайг сонгохдоо урьдчилан хэд хэдэн хэсэгт хувааж тэмдэглээд тус бүрээс авна.

3. Шинжилгээнд дээж авах

3.1. Дээж авахаар сонгож хэмжиж авсан талбайн дөрвөн өнцөг болон төв цэг дээрээс (0-20) см-ийн гүнээс тус бүр (300-500) г хөрсийг хүрз, хусуур, өрмийн багажийн аль нэгийг хэрэглэн авч сайн холино.

3.2. Шинжилгээнд дээж авах хөрсний давхарга гүний хэмжээ нь шинжилгээний зорилго, хөрсний бохирдолтын байдлаас хамааран цэг тус бүрд адилгүй байж болно.

3.2.1. Нийтийн орон сууц, цэцэрлэг, ясли, сургууль, амралт, сувилал, хүнсний үйлдвэр үйлчилгээний байгууллагууд, цэнгэлдэх хүрээлэн, айлын гэр, хашаа байшингийн орчмын хөрснөөс шинжилгээнд дээж авах гүний хэмжээ (0-15;0-25) см байна.

3.2.2. Үйлдвэр, ахуйн гаралтай хог хаягдал, бохир ус, шим бохирдол, бордоо химийн хорт болон цацраг идэвхт изотопоор бохирдсон талбайн хөрснөөс дээж авах гүний хэмжээ (0-25; 0-50) см 1,0 м байна.

3.2.3. Шарил оршуулга, мал амьтны сэг булсан газар, энгийн жорлон бохир усны нүхний ойролцоох хөрснөөс шинжилгээнд дээж авах гүний хэмжээ (1-2) м хүртэл байх боловч бохирдлын эх үүсвэр бүхий нүхний ёроолын түвшин гүнд нүх ухаж дээжийг авна.

3.2.4. Шинжилгээний зорилгоос хамаарч дээж авах талбайн хэмжээ, дээжийн төрөл, тоо ширхэг нь 1-р хүснэгтэнд заасантай тохирох ёстой.

1-р хүснэгт

Шинжилгээний зорилго	Дээж авах талай г-аар		Дээжний тоо
	нэг төрлийн бүтэцтэй хөрс	нэг төрлийн бус бүтэцтэй хөрс	
Хөрсөнд байгаа химийн бодис тодорхойлох	1-5	0,5-1	Нэгээс доошгүй нэгдсэн дээж
Хөрсний бүтэц ба физик шинж чанарыг тодорхойлох	1-5	0,5-1	Хөрсний үе давхарга бүрээс (3-5 ш) нарийвчилсан дээж
Өвчин үүсгэгч бичил ба вирус тодорхойлох	0,1-0,5	0,1	Тус бүр гурван нарийвчилсан дээжнээс бүрдсэн 10 нэгдсэн дээж авах

3.3. Хөрснөөс нарийвчилсан шинжилгээнд дээж авахдаа конвертын аргаар диагоналдан хуваасан талбай цэг тус бүрээс хөрсний нэг ба хэд хэдэн үе давхаргыг хамруулан (100-200) г дээж тус тусад нь савлана.

3.4. Шинжилгээний дунджилсан дээжийг дээж авахаар сонгосон талбайн тогтоосны цэгүүдээс авсан тусгаар сорьцуудыг (1х) м хэмжээний хулдаас буюу полиэтилен цаасан дээр нийлүүлэн асгаж холиод жигд тарааж дөрөв хуаасны нэгийг асган хольж тараах, асгах журмаар бэлтгэж нэг саванд савлаж авна.

3.5. Хөрсний онгон хэсэг болон үе давхаргуудад хүнд металл, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон байдлыг тодорхойлохын тулд хөрсний (0-5) см ба (0-5-20) см-ийн гүн дэх үед давхарга тус бүрээс (100-200) г-аас багагүй хэмжээний тусгаар дээжүүдийг авна.

3.6. Нян судлалын шинжилгээнд дээжийг ариутгасан багаж хэрэгслээр гадны бохирдолтоос хамгаалсан ариун нөхцөлөөр авч ариутгасан саванд тус тус савлана.

3.7. Гельминтологийн шинжилгээний дээжийг сонгосон талбайн 10 цэгийн өнгөн давхаргаас (5-10) см-ийн гүнээс тус тус авна.

4. Дээжийг тээвэрлэх, хадгалах

4.1. Хөрснөөс шинжилгээнд авсан дээж бүрт А хавсралтын дагуу дагалдах хуудас хөтлөх бөгөөд Б хавсралтын дагуу лабораторийн бүртгэлд дугаарлаж бүртгэнэ.

MNS 3298 - 90

4.2. Хөрснөөс шинжилгээнд авсан дээжийг бохирдол орохооргүй цэвэр уут саванд хийж, хөрсний чийг, температурыг алдагдуулахааргүй хамгаалсан нөхцөлд тээвэрлэн хадгалж 24 цагийн дотор лабораторид хүргэж шинжилгээнд өгнө. Хэрэв дээрх хугацаанд лабораторид хүргэх, шинжлэх боломжгүй бол хөргөгчид хийж (4-5)⁰C-ийн температурт 3 хоногоос 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

4.3. Физик химийн шинжилгээнд өгөх дээжийг тасалгааны температурт үнэмлэхүй хуурай болтол хатаана.

4.4. Дэгдэмтгий ба химийн тогтворгүй нэгдлүүдийг тодорхойлох, нян вирус тодорхойлох дээжийг хадгалахгүйгээр хүргэж дээж авсан өдөрт нь багтаан шинжилгээнд оруулна.

ТӨГСӨВ.

А Хавсралт (Заавал мөрдөнө)

Хөрснөөс шинжилгээний дээж авахад дагалдах хуудас

1. Хөрснөөс дээж авсан газрын нэр , хаяг
.....
.....
 2. Дээж авсанон.....сар.....өдөр
 3. Дээж авсан хүний нэр, албан тушаал.....
.....
 4. Дээж авсан газрын хөрсний ариун цэврийн байдал хэдэн жил ашиглагдсан.....үйлдвэр, ахуйн гаралтай бохир ус, хог, хаягдал, химийн бодис, хүн малын ялгадасаар бохирлогдсон байдал.....
.....
 5. Хөрснөөс дээж авсан гүн..... хэмжээ.....
 6. Шинжилгээний зорилго.....
.....
 7. Шинжилгээ хийх үзүүлэлтийн нэр.....
.....
 8. Шинжилгээний дээжийг лабораторид авч ирсэнон.....сар.....өдөр.....цаг.....минут
 9. Шинжилгээний дээжинд шинжилгээ эхэлсэнон.....сар.....өдөр.....цаг.....минут
 10. Дээжинд шинжилгээ хийж дуусанон.....сар.....өдөр.....цагминут
 11. Шинжилгээний дүн.....
.....
.....
 12. Шинжилгээ хийсэн химич, эмч.....
.....
- Дүгнэлт
-
.....
.....Ариун цэврийн байцаагч.....